



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 03

Бүрхээр

“Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус, хойшлогдсон хурал Хөвсгөл аймаг, Мөрөн сум, АЗДТГ-ын III давхар, “Иргэний танхим”-д 2022 оны 10 дүгээр сарын 24-ний өдрийн 11 цаг 00 минутад эхэллээ.

Хуралд нийт 829622 /Найман зуун хорин есөн мянга зургаан зуун хорин хоёр ширхэг хувьцааг төлөөлж хувьцаа эзэмшигч оролцохоос 423107 ширхэг хувьцааг эзэмшигч, орон нутгийн төлөөлөгч 1 биеэр оролцож хурал 51 хувийн ирцтэй болж Компанийн тухай хуулийн 69 дугаар зүйлийн 69.4 дэх заалтыг хангасан учир Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус, хойшлогдсон хурлын ирцийн тухай танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хойшлогдсон хуралд: Хувьцаа эзэмшигч

№	Овог нэр	Регистерийн дугаар	Хувьцааны тоо
1	Орон нутгийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Билэгт-Отгон		423107
Хуралд оролцсон нийт дүн			423107

Тооллогын комиссын дарга: Б.Одончимэг

Тооллогын комиссын гишүүн : М.Бүдханд

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга: Т.Урангэрэл нар оролцов.

Хурлын дарга хурлыг нээж хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус, хойшлогдсон хурлаар хэлэлцэхээр Хөвсгөл аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/48 дугаар захирамжаар баталсан хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон хурлын дэг, хуралд хүрэлцэн ирсэн орон нутгийн өмчийн төлөөлөл, хувьцаа эзэмшигчдийг танилцуулж, хурлыг нээв. /Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав/

Сонссон нь:

Д.Лхагвасүрэн (Хурлын дарга): Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. “Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус, хойшлогдсон хурлыг 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хуралдуулахаар товлон зарласан. Энэхүү хурлыг Компанийн тухай

хуулийн дагуу хэрхэн зарлаж, зохион байгуулсан талаар танилцуулж хурлын тэмдэглэлд тэмдэглүүлье.

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2-т Төлөөлөн удирдах зөвлөлийн 2 буюу түүнээс дээш хараат бус гишүүн, саналын эрх бүхийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал шаардлага гаргасан үед ээлжит бус хурал хуралдуулахаар зааж өгсөн. Үүний дагуу Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга Г.Мөнгөнхуяг 2022 оны 08 дугаар сарын 08-ны 1/296 тоотойр “Могойн гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Должинсорогдогт хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах санал, шаардлагаа хуульд заасан баримтын хамт хүргүүлсэн байна.

Үүнд “Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх ёстой. Гэвч 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон хурлаар хэлэлцсэн асуудлуудаар хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн олонхын шийдвэрээр бус 36.09 хувиар шийдвэр гаргасан нь хууль бус болох тухай Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 9/2533 дугаар бүхий албан бичгээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдэгдсэн. Иймд Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2 дахь заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ажлын 10 хоногт багтаан зарлахыг шаардаж байна. Хэрэв төлөөлөн удирдах зөвлөл ээлжит бус хурлыг зарлахгүй бол Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.7 дахь заалтыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргах болно” гэсэн байна.

Уг албан бичгийн хувьд аймгийн ИТХ-ын дарга Г.Мөнгөнхуяг аймгийн ИТХ-ыг шууд төлөөлөн санал, шаардлага гаргасан. Үүнийг мөн тайлбарлах нь зүйтэй.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд орон нутгийн өмчийн талаарх бүрэн эрхийг зааж өгсөн. Уг зүйлд “Аймгийн ИТХ нь аймаг, нийслэл, дүүргийн өмчийн бүх зүйлсийн хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна” гэж заасан. Уг хуулийн 77 дугаар зүйлийн 2-т “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй” гээд хэрэгжүүлэх бүрэн эрхүүдийг мөн заасан. Хуулийн 77 дугаар зүйлийн 3-т Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах, төлөөлөлтэй холбоотой эрхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ гэж заасан.

Аймгийн ИТХ-ын хурлын чөлөөт цагт Хурлын дарга өөрөө энэхүү хуулийн 77.2 дахь заалтыг үндэслэн “Могойн гол” ХК-ийн 51 хувийг төлөөлж, эрх үүрэг хүлээж байгаагийн хувьд шаардлага хүргүүлсэн байна. Санал, шаардлага хүргүүлсний дараа төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хуулийн 61.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг ажлын 10 өдөрт багтаан гаргах ёстой. Энэ талаар албан ёсны шийдвэр гараагүй учир Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.7-д “Энэ хуулийн 61.4-т заасан хугацаанд төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргаагүй тохиолдолд энэ хуулийн 61.2-т заасны дагуу санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус

гишүүн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно” гэж заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргасан байна.

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/48 дугаар захирамж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай захирамжид Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 35.1.11, 48.3, 52.1.10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.1, Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, 61.2, 61.7 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, “Могойн гол” ХК-ийн дүрмийн 7.2, 7.6, тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн “Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Хөвсгөл аймаг, Мөрөн сум, аймгийн ИТХ-ын дэргэдэх “Иргэний танхим”-д хуралдуулахаар зарлаж хурлаар хэлэлцэх асуудлыг батлан, хурал зохион байгуулах комисс, тооллогын комиссыг байгуулсан.

Энэхүү шийдвэрээр зарласан хуралд 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Компанийн тухай хууль, тус компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх хүрэлцэн ирээгүй учир хойшлуулж Компанийн тухай хуулийн 69.6-д заасны дагуу ээлжит бус, хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногт багтаан буюу 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хуралдуулах тухай шийдвэрийг аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/65 дугаар захирамжаар гаргажээ. Хуулийн дагуу хурал хуралдуулах газар, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, бүртгэх өдөрт өөрчлөлт оруулаагүй байна.

Уг захирамжийн дагуу ээлжит бус, хойшлогдсон хурлыг өнөөдөр хуралдуулж байна. Тооллогын комисс энэхүү ээлжит бус, хойшлогдсон хурлын ирц Компанийн тухай хуулийн холбогдох заалтыг хангаж байгаа эсэх тухай шийдвэрээ танилцуулна уу.

/Хурал даргалагчаас танилцуулсан холбогдох албан бичиг, шийдвэрийг хавсаргав/

Б.Одончимэг (Тооллогын комиссын дарга): Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хойшлогдсон хуралд нийт 829622 ширхэг хувьцааг төлөөлж хувьцаа эзэмшигчид оролцохоос 423107 ширхэг энгийн хувьцааг эзэмшигч, орон нутгийн өмчийн төлөөлөгч 1 биеэр оролцож хурал 51 хувийн ирцтэй болж байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 69 дугаар зүйлийн 69.4 дэх заалтыг хангаж байна.

Д.Лхагвасүрэн: Хурлын ирц хүрсэн учир хурлыг нээснийг мэдэгдье.

“Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурал болон 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит, хойшлогдсон хурлын үеэр өнөөдрийн хурлаар хэлэлцэж буй хэлэлцэх асуудлуудаар компанийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүд дэлгэрэнгүй танилцуулга, мэдээлэл албан ёсоор хийсэн. Тухайн хурлуудад орон нутгийн өмчийн төлөөлөгч Б.Билэгт-Отгон биечлэн оролцож мэдээлэлтэй бүрэн танилцсан.

Тиймээс өнөөдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус, хойшлогдсон хурлаас гарах шийдвэрийг албан ёсоор гаргах, батлах, шийдэгдээгүй бусад асуудлыг хэлэлцэн батлах ёстой. Орон нутгийн өмчийн төлөөлөгч саналын хуудсаар саналаа өгнө. Мөн хэлэлцэж буй асуудлуудаар санал гаргаж, асуулт тавих эрхтэй.

ХЭЛЭЛЦСЭН нь 1: Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг зөвшөөрөх эсэх тухай тухай

СОНССОН нь:

Б.Билэгт-Отгон: Хувьцаа эзэмшигчдийн хурал энэ онд 2 удаа хуралдсан ч хуулийн дагуу хүчин төгөлдөр болж шийдвэр гаргаагүй. Тухайн хурлуудад миний бие орон нутгийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувиар оролцсон. Тухайн үед хэлэлцэж буй асуудлуудаар албан ёсны мэдээлэл сонссон. Тиймээс сонссон дүгнэлтэндээ үндэслээд шийдвэр гаргаж саналаа өгнө.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайланг дүгнэсэн ТУЗ-ийн дүгнэлтийг зөвшөөрч, саналаа саналын хуудсаар өгөхөөр тогтов. Хурлын дарга тогтоолын төслийг танилцуулж, Тооллогын комиссын "Саналын хуудсыг тоолсон тухай" тогтоолыг үндэслэн 100 хувийн саналаар батлав.

ХЭЛЭЛЦСЭН нь 2: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны тайлан, зардлын төсвийн гүйцэтгэл болон 2022 оны зардлын төсвийн тухай

СОНССОН нь:

Д.Лхагвасүрэн: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай асуудлаар саналаа гаргана уу.

-Б.Билэгт-Отгон: Өмнө хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчид төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн урамшууллыг 1,000,000 төгрөг болгож нэмэгдүүлэх, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын цалинг 1,100,000 болгож нэмэгдүүлэх талаар санал гаргасан. Миний хувьд мөн дэмжсэн байр суурь илэрхийлж байсан. Тиймээс энэ саналыг хэвээр үлдээн батлах саналтай байна. Харин гадаадад туршлага судлах зардалд 50,000,000 сая төгрөг батлах санал гарч байсныг хасч батлах саналтай байна.

Шийдвэрлэсэн нь:

Хувьцаа эзэмшигчид Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны тайлан, зардлын төсвийн гүйцэтгэл болон 2022 оны зардлын төсвийн тухай, саналаа өгөв. Хурлын дарга тогтоолын төслийг танилцуулж, Тооллогын комиссын "Саналын хуудсыг тоолсон тухай" тогтоолын төслийг үндэслэн 100 хувийн саналаар батлав.

ХЭЛЭЛЦСЭН нь 3: Компанийн ногдол ашиг хуваарилсан тухай ТУЗ-ийн шийдвэрийг мэдээлэх

СОНССОН нь:

-Б.Билэгт-Отгон: “Могойн гол” ХК-ийн 2021 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Тухайн үед компанийн гүйцэтгэх захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч О.Ууганбаяраас ногдол ашиг хуваарилахгүйгээр, хөрөнгө оруулалтад цэвэр ашгийг зарцуулах тухай хүсэлт ирснийг аймгийн ИТХ-ын дарга зөвшөөрч ногдол ашиг хуваарилахгүй байх чиглэл өгсөн. Гэсэн ч төлөөлөн удирдах зөвлөл дийлэнх олонхийн саналаар нэгж хувьцаанд 600 төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргаж, ногдол ашгийг орон нутгийн болон хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлсэн байдаг.

Миний хувьд Хувьцаа эзэмшигчдийн хуралд аймгийн ИТХ-аас өгсөн удирдамжтай оролцож байгаа. Тиймээс удирдамжийн дагуу төлөөлөн удирдах зөвлөлөөс дийлэнх олонхийн саналаар гаргасан тухайн шийдвэртэй танилцаж, зөвшөөрч байна.

Шийдвэрлэсэн нь:

Хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилсан тухай төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрч байгаагаа илэрхийлэв. Хурлын дарга тогтоолын төслийг танилцуулж, Тооллогын комиссын “Саналын хуудсыг тоолсон тухай” тогтоолын төслийг үндэслэн 100 хувийн саналаар батлав.

ХЭЛЭЛЦСЭН нь 4: Хөрөнгө данснаас хасах тухай

Хурлын дарга санал гаргахыг мэдэгдэв.

СОНССОН нь:

-Б.Билэгт-Отгон: “Могойн гол” ХК-ийн байр, уурхай дээр ажиллах үедээ актлахаар санал оруулсан хоёр техникийг харсан. Ашиглах боломжгүй, бүрэн зогссон, засварлах боломжгүй тухайн хоёр техникийг актлах саналыг дэмжиж байна.

Шийдвэрлэсэн нь:

Хувьцаа эзэмшигчид компаниас оруулсан саналын дагуу ашиглалтын хугацаа дууссан хоёр техникийг /белаз, Трекс/ актлах санал гаргаж, саналаа саналын хуудсаар өглөө. Хурлын дарга тогтоолын төслийг танилцуулж, Тооллогын комиссын “Саналын хуудсыг тоолсон тухай” тогтоолын төслийг үндэслэн 100 хувийн саналаар батлав.

ХЭЛЭЛЦСЭН нь 5: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож, томилох тухай**СОНССОН нь:**

Д.Лхагвасүрэн: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн материалыг танилцуулна уу.

Т.Урангэрэл: Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд зарласан. Тухайн үед төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах шаардлага, шалгуурыг батлан 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөр тасалбар болгон холбогдох материалыг хүлээн авсан. Хараат бус гишүүн сонгон шалгаруулах зарын дагуу нийт 8 нэр дэвшигчээс цаасан хэлбэрээр болон цахимаар материал хүлээн авсан. Үүнийгээ шаардлага, шалгуурын дагуу материал ирүүлсэн эсэхийг тэмдэглэж, баталгаажуулан Нэр дэвшүүлэх хорооны дарга Б.Должинсорогдогт хүлээлгэн өгсөн.

Ердийн гишүүнд нэрээ дэвшүүлж хувьцаа эзэмшигч Ж.Батболд, Н.Батдорж, Л.Батдэлгэр нар хүсэлт, анкетаа мөн Нэр дэвшүүлэх хороонд өгсөн.

Д.Лхагвасүрэн: Орон нутгийн өмчийг төлөөлж төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах ердийн гишүүдэд аймгийн ИТХ-ын ажлын албаны ахлах ажилтан Б.Билэгт-Отгон, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга М.Алтаншагай, аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан Б.Сумъяабат нарыг дэвшүүлсэн аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн тогтоол хувьцаа эзэмшигчдийн хуралд албан ёсоор ирсэн байна. Эдгээр нэр дэвшигчдийн материалыг саналын хуудсанд нэрийг оруулъя.

Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн Нэр дэвшүүлэх хороонд өгсөн материалаас харахад 8 нэр дэвшигч бүгд Компанийн тухай хуульд заасан ерөнхий шаардлагыг хангаж байгаа учир саналын хуудсанд нэрийг нь оруулах нь зүйтэй.

Шийдвэрлэсэн нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч 6, хараат бус гишүүнд нэрээ дэвшүүлсэн 8 нэр дэвшигчийн нэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудсанд оруулж, хувьцаа эзэмшигч саналаа өгөв. Хурлын дарга тогтоолын төслийг танилцуулж, Тооллогын комиссын Кумульятив аргаар өгсөн саналын хуудсыг тоолсон дүнгийн тухай тогтоолыг үндэслэн 100 хувийн саналаар батлав.

Хуралдаан 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 12.20 цагт дууслаа. Хурлын дарга хуралдааныг хааж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг хууль, журамд заасан хугацаанд хороо, арилжээ эрхлэх байгууллагад хүргүүлэхийг үүрэг болголоо.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Т.Урангэрэл* УРАНГЭРЭЛ

ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ:

Б.БИЛЭГТ-ОТГОН